



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019ны 01 сарын 11 одор

Дугаар A/01

Улаанбаатар хот

Шалгах багийг томилох тухай

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн ХЭГ/21, Зам, Тээврийн Хөгжлийн Яамны 2019 оны 01 дүгээр сарын 08-ний өдрийн 03/80 тоот албан бичгээр ирүүлсэн албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, албаны дүрмийн 2.2-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Иргэний нисэхийн хяналт НҮ-ТББ" териин бус байгууллагын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 21, 22 тоот албан бичгүүдэд дурьдагдсан нислэг, техникийн тохиолдлуудыг шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шалгах багийн ахлагч:

Х.НАРАНХҮҮ Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч,

Гишүүд:


Б.ЧИНЗОРИГ Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч,

С.БАТТУЛГА Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны мэргэжилтэн,

2. Шалгалтыг Иргэний нисэхийн тухай хууль, албаны дүрмийн дагуу хийж гүйцэтгэхийг багийн ахлагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ж.ЦОЛМОН





НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 6/04

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн гэрээний загвар батлах,
хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 21, 23, 24 дүгээр зүйлийн заалтууд, НТОЗШША-ны дүрмийн 4 дүгээр бүлгийн 4.4.5 дахь заалт болон Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар бүлгийн 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ажилтнуудтай байгуулах хөдөлмөрийн гэрээний загварыг 1 дүгээр хавсралтаар, ажил олгогчийг төлөөлж ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хөдөлмөрийн гэрээний шинэчилсэн загварыг 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн мөрдөж, ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг байгуулах ажлыг 05 сарын 10-ны дотор багтаан дуусгахыг хөдөлмөрийн гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 5/07

Улаанбаатар хот

Г Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай Г

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Монгол улсын хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, Хөдөлмөрийн дотоод журмын 2.8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны ажил үүргийг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны техникийн шинжээч И.Энхчулуунд хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

2. Хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, төлөвлөх, зохион байгуулах, ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг шинжээч /И.Энхчулуун/-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ж.ЦОЛМОН





НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗОРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 4/08

Улаанбаатар хот

Ослын газар дээрх хөдөлмөрийн аюулгүй
ажиллагааны заавар батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Монгол улсын хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1, Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын баримт бичиг DOC9756, Р1-ийн 5 дугаар бүлгийн 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинэчлэн боловсруулсан "Ослын газар дээрх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар"-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Ослын газар дээрх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааврыг танилцуулан, сурталчилж, сургалтын хөтөлбөр гаргаж ажиллахыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан /И.Энхчулуун/-д даалгасугай.
3. Ослын газар дээрх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааврыг 2019 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг шинжээч нарт үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ж.ЦОЛМОН





НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 19 өдөр

Дугаар A/12

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журам
шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай Монгол улсын хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, 130 дугаар зүйлийн 130.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Хөдөлмөрийн дотоод журмыг хэрэгжүүлж ажиллахыг нийт ажилтнуудад, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг Захиргаа, судалгааны тасаг /П.Гэрэлчимэг/-т үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ж.ЦОЛМОН





НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 4/13

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Шинжлэн шалгах ажиллагаанд шинжээч нарын бэлэн байдлыг хангах, ICAO Circular 298-AN/172 "Training Guidelines for Aircraft Accident Investigators", DOC 9756 Manual of Aircraft Accident and Incident Investigation" P1, 5.4, 5.5 дахь заалт, ИНЕГ-ын "Гадны сургалтын байгууллагуудад 2019 онд зохион байгуулагдах дотоод сургалтын төлөвлөгөө"-ний 11.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутгийн "Шар Товгор" хэмээх газарт 2019 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс 11-ний өдрүүдэд зохион байгуулагдах "Шинжлэн шалгах ажиллагааг хээрийн нөхцөлд явуулах дадлага, сургалт"-д ахлах шинжээч Х.Наранхүүгээр ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилон ажлуулсугай.
2. Дадлага, сургалт хийх удирдамжийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Дадлага, сургалтын төсвийг ИНЕГ-ын "Гадны сургалтын байгууллагуудад 2019 онд зохион байгуулагдах дотоод сургалтын төлөвлөгөө"-ний дагуу хоёрдугаар хавсралтаар баталсугай.
4. Дадлага сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, тайланг зохих журмын дагуу гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Х.Наранхүү/-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 14/14

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.3.7 дахь заалт, “Гадны сургалтын байгууллагуудад 2019 онд зохион байгуулагдах дотоод сургалтын төлөвлөгөө”-ний 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо”-нд 2019 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр зохион байгуулагдах “Архив албан хэрэг хөтлөлтөд анхаарах зүйлүүд болон баримт бичгийн стандартын хэрэгжилт” сургалтад Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны оператор О.Тэгшжаргалыг хамруулсугай.
- Сургалтын зардалд 80,000 /наян мянга/ төгрөгийг зохих журмын дагуу олгосугай.
- Сургалтын тайлан гаргаж Нисэхийн сургалтын төвд хүлээлгэн өгөхийг О. Тэгшжаргалд тус тус үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ж.ЦОЛМОН





НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар A/15

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

“Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, тэдгээрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д заасны дагуу Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр 2019 оны 11 дүгээр сарын 26 - ны өдөр, Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр буюу “Монгол бахархлын өдөр” 2019 оны 11 дүгээр сарын 27 - ны өдөр бүх нийтээр амрахтай холбогдуулан 2019 оны 11 дүгээр сарын 25 - ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 28 - ны өдрийг хүртэлх 3 хоногийн хугацаанд хариуцлагатай жижүүр томилох зорилгоор ТУШААХ нь:

1. Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр болон “Монгол бахархлын өдөр”-ийг тохиолдуулан нийтээр амрах баярын өдрүүдэд Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас ажиллах хариуцлагатай жижүүрийн ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баярын өдрүүдэд үндсэн үүрэгт ажил болон нислэг техникийн осол, зөрчлийн талаар дүрмийн дагуу мэдээ, мэдээллээр хангаж танилцуулахыг хариуцлагатай жижүүрт үүрэг болгосугай.

3. Баярын өдрүүдэд ажилласан хариуцлагатай жижүүрт хяналт тавьж ажиллах, энэ хугацаанд гарсан мэдээ, мэдээллийг нэгтгэж танилцуулахыг Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч О. Бат-Оршиход даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ж.ЦОЛМОН





**НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 12 сарын 17 өдөр

Дугаар A/16

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын 5.1, Иргэний нисэхийн багц дүрэм 203-ын 8.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын алт компанийн JU-6600 бүртгэлийн дугаартай Ми-8 АМТ маягийн нисдэг тэрэг 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Чингис хаан олон улсын нисэх буудлаас хөөрсний дараа нислэгийн үед баруун хөдөлгүүр унтарсан шалтгааныг тогтоох шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч:

Х.Наранхүү, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч

Гишүүд: О.Бат-Орших, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны нислэгийн шинжээч

Я.Энхбаяр, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

2. Шинжлэн шалгах ажиллагааг Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралт, албаны "Aircraft Accident Investigation Policy and Procedures Manual"-ын дагуу хийж гүйцэтгэхийг багийн ахлагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ж.ЦОЛМОН





НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 4/17

Улаанбаатар хот

Урамшуулал олгох тухай

Зам, Тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 171 тоот тушаалаар батлагдсан “Нислэг, техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийн 4.4.9, 4.4.10 дахь заалтууд, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.9.2 заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын жилийн эцсийн ажлын үр дүн, удаан жил үр бүтээлтэй ажиллаж байгааг харгалзан тус албаны ажилтнуудад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгосугай.
2. Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад урамшуулал олгохгүй байхад зохих журмын дагуу хяналт тавихыг Захиргаа, судалгааны тасаг /П.Гэрэлчимэгт/-т даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ж.ЦОЛМОН

